



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/566

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон сууцны байрны орчны болон орчны нийтийн эзэмшлийн талбайн ариун цэврийг сайжруулж, агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор байрны орц болон орчны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг гүйцэтгэж буй Жаргалант сумын Сууц өмчлөгчдийн холбоодын үйлчлэгчдийн ажлын урамшууллын санхүүжилтэд 13500.0 мянган төгрөг /арван гурван сая таван зуун мянган/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус урамшуулалд зарцуулах 13500.0 мянган төгрөгийг аймгийн 2020 оны төсөвт батлагдсан агаар орчны бохирдолыг бууруулах арга хэмжээний санхүүжилтээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Ажлын урамшууллыг Сууц өмчлөгчдийн холбооны үйлчлэгч нарын хариуцсан орон сууцны орц, орчны цэвэрлэгээ, үйлчилгээг бүрэн хангуулахаар гэрээлэн ажлын гүйцэтгэлийн биелэлт, түүний чанар, үр дүнг үндэслэн сар бүр тооцож, санхүүжүүлэхийг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 01-ний өдрийн
А/566 дугаар захирамжийн хавсралт

ОРОН СУУЦНЫ ОРЦ БОЛОН ОРЧНЫ ХОГ ХАЯГДЛЫГ
ЦЭВЭРЛЭХ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

д/д	Үзүүлэлт	Үйлчлэг- чийн тоо	Нэг хүнд олгох сарын урамшуулал /төгрөг/	Олгох хугацаа /сар/	Урамшуулалын нийт дүн /мянган төгрөг/
1	"Их монгол" СӨХ	2	150000.00	2	600.0
2	"309 дүгээр" СӨХ	11	150000.00	2	3300.0
3	"Оргил" СӨХ	9	150000.00	2	2700.0
4	"ЭСБА" СӨХ	4	150000.00	2	1200.0
5	"Домбот" СӨХ	1	150000.00	2	300.0
6	"Сайн өдтэй бичиг" СӨХ	1	150000.00	2	300.0
7	"Цамбагарав 19" СӨХ	7	150000.00	2	2100.0
8	"120" СӨХ	9	150000.00	2	2700.0
9	"108" СӨХ	1	150000.00	2	300.0
Дүн		45			13500.0

-оОо-